

**Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог**

**дэмжих төсөл (DPUB)**

Мэдээллийн эмхэтгэл № 8 (2018 он 2-р сар)

**НҮБ дэх дадлага**

6-р давхрын Нийгмийн хөгжлийн хэлтэст анх очсон дүр зургийг одоо ч тодхон санаж байна. Мэргэжилтний өрөөний үүдний 2 талд нь нарийн бичгийн ширээг зэрэгцүүлэн тавьсан маш тохилог оффисыг хараад ямар гоё юм бэ, аргагүй л НҮБ юм даа... гэж бодов. Нарийн бичгийн ажилтанд өөрийнхөө нэрийг хэлтэл намайг мэргэжилтний өрөө рүү дагуулж орлоо. Тэгээд намайг тэргэнцэртэй мэргэжилтэн Такаминэ Ютакатай танилцууллаа. Анх хараад яагаад тэргэнцэртэй хүн юм бол? гэж жаахан гайхсан ч НҮБ юм чинь байдаг л зүйл байлгүй дээ гэж бодов. Гэтэл Такаминэ мэргэжилтэн надад “Маргаашнаас 1 долоо хоног томилолтоор явна” гэдгээ хэллээ. Маргаашнаас томилолтоор явчих юм бол намайг хариуцан ажиллах хүн байхгүй юм байна. Тайландад ингэж яарч ирж байхад гэнэт амрана гэдэг чинь... НҮБ юм байж ямар хариуцлагагүй юм бэ... гэж бодож эхэллээ.

Ингээд амралт дууссаны дараа Сан Юнва гэдэг малайз эмэгтэйтэй танилцлаа. Хатагтай Юнва миний дадлагын удирдагч болох хүртэл би НҮБ-д дадлага амжилттай хийчих юм байна гэсэн бодолтой байсан юм. Намайг Нийгмийн хөгжлийн хэлтсийн Хөгжлийн бэрхшээлийн группт дадлага хийхээр хуваарилсан байлаа. Тэр үед НҮБ яагаад Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг юм бол оо... гэж гайхан бодож байсан. Хөгжлийн бэрхшээл гэдгийг эмчилгээ, сэргээн засалт зэргээр л төсөөлдөг байсан бөгөөд үнэнийг хэлэхэд тийм хүмүүст тусламж дэмжлэг үзүүлэх аргачлалын талаар нэг их сонирхдоггүй байв. Гэхдээ тухайн үед би буруу бодож байсан бөгөөд цаашид хөгжлийн бэрхшээлийн салбарт ажиллана гэдгээ ч төсөөлж байгаагүй юм. (Үргэлжлэл бий...)



DPUB төслийн ахлах зөвлөх Чиба

**Стандарт, Хэмжил зүйн газарт DET сургалт зохион байгуулагдлаа**

2018.02.09



DET сургалтын дараах дурсгалын зураг

2-р сарын 2-ны өдөр Стандарт, Хэмжил зүйн газарт DET сургалт зохион байгуулагдсан бөгөөд барилга байгууламж, зам гэх мэт салбар бүрийн стандартыг боловсруулах чиглэлээр ажилладаг 12 мэргэжилтэн хамрагдлаа. Тус байгууллагын зүгээс энэ онд Хэмжил зүйн байгууллага үүсч

хөгжсөний 95 жилийн ой тохиож буйтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй орчинг бүрдүүлэх чиглэлээр холбогдох ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. Энэ удаагийн сургалтын үндсэн сургагч багшаар Тунгалагтамир (хөдөлгөөний бэрхшээлтэй) ажиллаа. Түүний хувьд анх удаа үндсэн сургагч багшаар ажилласан учраас бага зэрэг сандралтай байсан хэдий ч сургалтанд оролцогчидтой байгууллагат нь тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар харилцан ярилцаж, сургалтыг амжилттай чиглүүлэн явуулсан. Сургалтын төгсгөлд оролцогчид “Барилга байгууламжийн стандартыг холбогдох байгууллагууд ханган ажиллаж байгаа эсэх дээр хяналт шаардлагатай”, “DET сургалтанд хамрагдсанаар нэн түрүүнд хүмүүсийн ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгтэй гэдгийг анзаарлаа” гэх мэтээр өөрсдийн сэтгэгдлийг хуваалцлаа.

**Дэд бүтцийн хүртээмжтэй орчныг сайжруулах тухай**

2018.02.08



Ахлах мэргэжилтэн Мөнхболд

Барилгын хөгжлийн төвийн ахлах мэргэжилтэн Мөнхболдтой уулзалт хийлээ. Тус төвийн мэргэжилтнүүд барилгын зураг төсөлд магадлал хийдэг бөгөөд зураг төслийн зөвшөөрөл гарсны дараа барилгын ажил эхэлдэг. Зураг төслийн шалгах хуудсанд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчинг бүрдүүлэх хэсэг тусгагдсан байдаг хэдий ч шалгах хуудасны агуулга их учраас анзаарахгүй орхигдуулах, ач холбогдол өгөхгүй байх тохиолдол гардаг байна. Бид энэ удаа төвийн албан хаагчдад зориулсан сургалт хийх тухай ярилцсан бөгөөд цаашид дэд бүтцийн хүртээмж, хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын талаарх сургалтуудыг хамтран зохион байгуулахаар боллоо. Сургалтын үр дүнд тус төвийн албан хаагчдын ойлголт улам гүнзгийрч, түүнийгээ өөрсдийн ажилдаа тусган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!



Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **1320** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.



## Япон дахь сургалтын тайлангийн хурал зохион байгуулагдлаа

2018.02.06

1-р сарын 31-ний өдөр Япон улсад зохион байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх” сэдэвт сургалтанд оролцогчдын тайлангийн хурал зохион байгуулагдлаа. Тус хуралд төр, төрийн бусын 60 гаруй төлөөлөл оролцсон. Сургалтанд оролцсон хүмүүс Япон улсын нийтийн тээвэр, барилга байгууламжийн хүртээмж, ХБИ-ийн бие даах амьдрал, хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал гэх мэт сэдвүүдээр тайлан тавьлаа. “Японы галт тэрэгний буудалд шувуу жиргэх, ус урсах чимээ сонсогддог бөгөөд энэ чимээ нь харааны бэрхшээлтэй иргэдэд шат, ариун цэврийн өрөөний байршлыг зааж өгдөг.” “ХБИ-ийг ажилд авсныхаа дараа тухайн хүнийг тогтвортой ажиллуулах чиглэлээр дэмжлэг үзүүлдэг” зэрэг тэдний яриаг оролцогчид чих тавин сонсож байсан юм. Тайлангийн дараа хуралд оролцогчид “Сурсан мэдсэн зүйлээ цаашид хэрхэн хэрэгжүүлэх вэ?”, “Бие даан амьдрахад шаардлагатай туслах ажилтны зардлыг яаж шийддэг вэ?” гэх мэт олон асуулт асууж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Энэ утгаараа төр, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



Хурлын үеэр



Хэлэлцүүлэг хийж байна



## DET сургалтыг бизнесийн байгууллагуудад!! ~Хаан банк~

2018.02.05



DET сургалтын үеэр

1-р сарын 31-ний өдөр Хаан банкны Хүний нөөцийн хэлтсийн 20 ажилтан Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-д хамрагдлаа. Монголын хамгийн том банкинд дээр болсон тус сургалтын үндсэн сургагч багшаар Энхням (хөдөлгөөний бэрхшээлтэй) ажилласан. Тэрээр DET Форумын тэргүүн юм. Өглөө эрт зохион байгуулагдсан тус сургалтанд хүний нөөцийн үйл ажиллагаа, удирдлагын газар, сургалтын албаныхан оролцсон. Сургалтын эхэнд ихэнх оролцогчид “Хөгжлийн бэрхшээл нь хүнд байдаг” гэж байсан боловч дасгал ажлуудын дараа “Хөгжлийн бэрхшээл нь орчин, хүмүүсийн хандлагаас бий болж үүсдэг юм байна” гэж өөрчлөгдсөн байлаа. Мөн дохионы хэл мэддэг хүн дутмаг, хаалганы өргөний хэмжээ хангалтгүй гэх мэт өөрсдийн эргэн тойрны асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж болох талаар ярилцлаа. Сургалт хариуцсан менежер Амармөнх “Зөвхөн багш л яриад байх бус оролцоонд тулгуурласан, оролцогчид өөрсдөө асуудлын талаар бодож гаргадаг аргачлал их таалагдлаа” хэмээн сэтгэгдлээ хуваалцлаа. Хаан банкны хувьд цаашид “Бүх хүнд ээлтэй” загвар байгууллага болох зорилт тавин ажиллаж байна.

## Бүх хүнд ээлтэй нисэх онгоцны буудал болохын тулд ...

2018.02.08



Чингис хаан нисэх онгоцны буудал дээр

Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын Хэрэглэгчийн харилцааны маркетинг судалгааны мэргэжилтэн Тунсагтай уулзалдан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг хэрхэн бүрдүүлэх талаар ярилцлаа. Тус нисэх онгоцны буудалд ойролцоогоор 800 гаруй албан хаагчид ажилладаг бөгөөд хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр сургалт авах хүсэлтэй байгаа юм. Төслийн зүгээс мэдлэг, ойлголт өгөх Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалтыг зохион байгуулах, ХБИ-д үзүүлэх үйлчилгээний арга барил, мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн талаар лекц унших гэх мэтээр хамтран ажиллах боломжтой гэдгээ илэрхийллээ. Тус сургалтуудыг 5-р сараас эхлэн зохион байгуулахаар төлөвлөж байна. Одоогийн байдлаар шинэ нисэх онгоцны буудлын барилгын ажил явагдаж байгаа бөгөөд улс орны нүүр царай болох тусгай объект гэдэг утгаараа дэд бүтэц • мэдээлэл • үйлчилгээний тал дээр хүртээмжтэй буудал болно гэдэгт найдаж байна.

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: [dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)